

Хот байгуулалт, төлөвлөлтийг боловсронгуй
болгох тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хот байгуулалт, төлөвлөлтийг боловсронгуй болгох асуудал” сэдэвт хэлэлцүүлгээс гаргасан санал, дүгнэлттэй ажлын журмаар танилцаад ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Монгол Улсын Засгийн газарт дараах чиглэлийг өгөв. Үүнд:

1. Улаанбаатар хотын хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг 2011 онд багтаан тодотгон шинэчилж, гамшгаас хамгаалах арга хэмжээг иж бүрэн тусгах;
2. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг багасгах зорилгоор нийслэл орчмын суурьшлын бүсүүд, дагуул хотуудыг хөгжүүлэх, тэдгээрийг холбосон өндөр хурдны авто зам, гүүр, эрчим хүч, инженерийн шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн байгууламж бүхий төлөвлөгөөг 2011 оны эхний хагас жилд багтаан шинэчлэн боловсруулах;
3. Улаанбаатар хотын авто зам, дулаан, цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усан хангамжийн сүлжээ зэрэг дэд бүтцийн байгууламжийн төлөвлөлтийг нэгдсэн байдлаар гүйцэтгэх;
4. 2011 оны эхний хагас жилд багтаан хороолол, хотхоны барилгуудаас төлөөлүүлэн паспортжуулах замаар нийслэлийн барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх байдлын эхний шатны ерөнхий үнэлгээг гаргах;
5. Барилга байгууламжуудын газар хөдлөлтийн тэсвэрлэх байдлын үзлэг шалгалтыг улсын хэмжээнд 2012 онд багтаан хийж дуусгах. Уг ажлыг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, төрийн бус байгууллага, иргэдээс хяналт тавих механизмыг бүрдүүлэх;

6. Газар хөдлөлтийн гамшгийн нэгдсэн төлөвлөгөөнд шаардлагатай нэмэлт, тодотголыг хийх;

7. Улаанбаатар хот дахь ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтийн чичиргээ даахгүй болох нь тогтоогдсон 44 барилгыг эхний ээлжинд даруй буулгаж, шинэчлэн барих арга хэмжээг авах;

8. Үндэсний хэмжээний эрсдэлийн менежментийн чадавхийг төлөвшүүлэх, бэхжүүлэх зорилгоор шаардлагатай боловсон хүчнийг дотоод, гадаадын их, дээд сургууль, судалгааны байгууллагад сургаж бэлтгэх эхний шатны ажлыг 2011-2013 онд хэрэгжүүлэх;

9. Монгол Улсын хот тосгон, суурин газар бүрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, газар хөдлөлийн бичил мужлалын зураглалыг 2012 онд багтаан хийж дуусгах;

10. Сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийг эхний ээлжинд паспортжуулж, ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг нэн даруй буулгах, шаардлагатай барилгуудыг бэхэлж, хүчитгэх арга хэмжээг авах.